



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 59

Жаргалант

Г

Т

Үндсэн хөрөнгийг шинээр
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, 25 дугаар зүйлийн 25.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Соёлын төвийн “Орон нутгийг судлах танхим”-ыг Хөдөлмөрийн гавьяаны Улаан түгийн одонт, Монголын Урчуудын Эвлэлийн гишүүн, нэрт уран сийлбэрч Навааны Лувсанцэрэнгийн нэрэмжит болгосонтой холбогдуулан түүний үр хүүхэд, төрөл, төрөгсөд, сумын Хурлын төлөөлөгчдөөс хандивласан 8390.0 мянган төгрөгийн өртөгтэй техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, уран бүтээлийн болон соёлын өвийн үнэт зүйлсийг Соёлын төвийн байгууллагын үндсэн хөрөнгийн балансад бүртгэхийг зөвшөөрч, жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Сумын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга, Соёлын төвийн эрхлэгч, нягтлан бодогч нарт Даалгах нь:

2.1. Үндсэн хөрөнгийг шинээр бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу сум, байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулах.

2.2. Соёлын төвийн “Орон нутгийг судлах танхим”-д хандиваар өгсөн хөрөнгө, техник хэрэгслийг хөрөнгийн зохих ангилалд бүртгэн дансалж, хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллах.

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгасныг “Төрийн болон орон нутгийн өмчийг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.

3. Тогтоолын хэрэгжилт үр дүнг тооцож, биелэлтийг гаргуулан хагас, бүтэн жил тутам ИТХ-д ирүүлж ажиллахыг ЗДТГ-ын дарга /Г.Нямханд/-д биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын дэргэдэх /Төсөв санхүү, хяналт шалгалтын хороо/-нд болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Бямбадорж/-д даалгасугай.



ДАРГА

Г. БЯМБАСҮРЭН

D:\Ter\togtool.docx